

## **“ЭРДЭНЭТИЙН ДЦС” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

### **I. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

2022 онд “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК нь бүтэц, зохион байгуулалтаар 1 алба, 5 хэлтэс, 8 цехийн зохион байгуулалттай, 461 хүний орон тоотой ажиллалаа. Өргөтгөлийг ашиглалтад хүлээж авснаар компанийн 4 цехэд ажлын зайлшгүй шаардлагатай байгаа 14 орон тоог нэмж батлуулахаар санал оруулж 2022 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 04 тоот ТУЗ-ийн тогтоолоор нийт ажилтнуудын тоог 464 болгон баталсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Улсын Их Хурал болон Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд дэд дарга, орлогч даргатай байхыг хориглох” гэсэн заалтын дагуу дэд захирлуудын орон тоог хасаж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дүгээр сарын 17-ний өдрийн 20 тоот тогтоолоор тус компанийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг өөрчлөн 461 хүнээр баталсан.

2022 оны байдлаар нийт 461 ажилтнууд ажиллаж байгаагаас 123 ИТА, 338 мэргэжилтэй ажилтнууд, үүний 78.5% буюу 362 ажилтан нь эрэгтэй, 99 буюу 21,7% эмэгтэй ажилтнуудтай. Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан нийт 7 ажилтан байна.

### **II. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

- ЦЭХ үйлдвэрлэлт, түгээлтийн биелэлт, дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч:

2022 онд тодотгосон төлөвлөгөөгөөр 434.5 сая.кВтц ЦЭХ боловсруулж, 375.4 сая.кВтц ЦЭХ түгээх төлөвлөгөөтэй. Гүйцэтгэлээр 427.1 сая.кВтц цахилгаан эрчим хүч боловсруулан, 369.1 сая.кВтц цахилгаан түгээж, түгээлтийн төлөвлөгөөг 98.3 хувиар биелүүлсэн.

Нийт боловсруулсан ЦЭХ-ний 13.59 хувийг дотоод хэрэгцээндээ хэрэглэхээр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 13.59 хувьтай ажиллаж биет хэмжээгээр төлөвлөгөөнөөс 992.5 мян.кВтц-аар бууруулсан.

Дулааны эрчим хүчийг 680.9 мян.Гкал үйлдвэрлэж, 637.2 мян.Гкал дулаан түгээхээр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 692.7 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, 641.5 мян.Гкал дулаан түгээж, төлөвлөгөөг 101.7 хувиар биелүүлсэн. Төлөвлөсөн хэмжээнээс түгээлтийг 4.4 мян.Гкал-аар нэмэгдүүлсэн.

Нүүрс, мазут: Төлөвлөгөөгөөр 593 мян.тн нүүрс уурхайнуудаас худалдан авч, 576.4 мян.тн нүүрс зарцуулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр нийт 566.2 мян.тн нүүрс орлогод авч 560.6 мян.тн нүүрс эрчим хүч үйлдвэрлэлд зарцуулж, 15.8 мян.тн нүүрс төлөвлөгөөнөөс хэмнэгдэж гарсан.

Дулаан гаргах чадварын зөрүүгээс 9.188 мян.тн нүүрс, илүү түгээсэн дулаанд 1.638 мян.тн-ыг хэтрүүлж, дутуу түгээсэн цахилгаанд 5.375 мян.тн-ыг, түлшний хувийн зарцуулалтын бууралтаас 21.234 мян.тн-ыг тус тус хэмнэсэн байна.

2022 онд тодотгосон төлөвлөгөөгөөр 83.2 тонн мазут төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 100 тонныг зарцуулж 16.8 тонныг төлөвлөгөөнөөс нэмж түлсэн байна.

Ус: Технологийн хэрэгцээнд 2143.98 мян.тн ус зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1997.71 мян.тн усыг гаднаас худалдаж авч, 146.27 мян.тн усыг төлөвлөсөн хэмжээнээс хэмнэсэн.

• **Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт:** 2022 онд үндсэн болон туслах тоноглолын их засвараар 43 ажлыг 7,655.0 сая төгрөг, техник зохион байгуулалтын арга хэмжээний 13 ажлыг 1,606.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 80 ширхэг сэлбэг материал, тоног төхөөрөмжийг 1,168.4 сая төгрөг, нийт 10,429.9 сая төгрөгийн 80 ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.

№	Зардлын төрөл	2022 оны төлөвлөгөө		2022 оны гүйцэтгэл		Биелэлт хувь
		тоо	сая.төг	тоо	сая.төг	
1	Их засвар	43	7,655.0	41	7,472.5	97.7%
2	ТЗБАХ	13	1,606.2	12	1,569.3	94.2%
3	Хөрөнгө оруулалт	80	1,168.4	78	1,140.7	96.1%
Нийт		136	10,429.6	131	10,182.5	96.0%

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын нийт 136 ажлаас 131 ажил, тоног төхөөрөмжийг 10,182.5 сая төгрөгт худалдан авч нийт гүйцэтгэл 96.0%-тай байна. 247,0 сая төгрөг хэмнэсэн байна.

Үндсэн тоноглолын их засварын 3 ажил хийгдэхээр төлөвлөсөн. Үүнд: ПВ-30 ПВД №1"-ийн зүрхэвч солих" ажил тус тус 100%-тай хийгдэж "Зуух №3-ын их засвар"-ын ажил, "Үнсэн сан №1-ийн үнсийг хоослох" ажлуудын 2022 оны гүйцэтгэл 100%, 2023 онд үргэлжлэн хийгдэнэ.

Туслах тоноглолын их засварын 40 ажлаас 38 ажил 100%, 2 ажил материал хүлээгдэж байна. Биелэлт 97,7% Үүнд:

- Дотоод хэрэгцээний дулааны шугам хэсэгчлэн солих /ногооны хүлэмж, авто гаражууд, өргөтгөлийн ахуйн байр, жолооч нарын ахуйн байр/ гүйцэтгэл 50%. Уг ажлын материалууд тендер шалгаруулалттай холбоотойгоор хойшилж 11 дүгээр сарын сүүлээр ирсэн тул ажлыг ондоо багтаагаад хийх боломжгүй болж ирэх онд хийхээр болсон.
- ТЭМ-1285 илчит тэрэгний 6 хос дугуйн их засвар - гүйцэтгэл 50%. УБ төмөр зам 11-р сард сэлбэг материалыг бүрэн авч засварлахаар тохиролцсон. Хазаарбат ХХК-тай сэлбэг материал нийлүүлэх гэрээ хийж, сэлбэгийг 100% бүрэн авсан. УБ төмөр засварын ДЕПО-тай 2023 оны 1-р сарын 15-наас гэрээ хийж засварт оруулахаар төлөвлөж байна.
- ТЗБАХ-ын 13 ажлаас 12 ажил бүрэн хийгдэж дууссан ба 1 ажил 30%-ийн гүйцэтгэлтэй гэрээ хийгдсэн байна. Биелэлт 94,2%

- Зуух №3,4-ийн модулиуд контроллер, програм хангамжийн шинэчлэл-гүйцэтгэл 30%-тай. “Хэрлэнгийн боргио” ХХК гэрээ хийсэн. Тайвань улсаас материал захиалга хийгдэж, нийлүүлэгдэхээр хүлээгдэж байна. 2023 онд ажил хийгдэнэ.

Өөрийн хөрөнгө оруулалтаар авах 33 нэр төрлийн 80 ширхэг сэлбэг материал худалдан авахаас 29 нэр төрлийн 78 ширхэг сэлбэг материалыг авсан ба 2 тоноглолыг худалдан авахаар гэрээ байгуулан хүлээж байна. Биелэлт 96,1%

- Үлээх салхилуурын цахилгаан хөдөлгүүр 4A355M8У3 160 кВт, 380/660 В, 305/176 А, АҮК-93%, Cosφ-0.85, 735 об/мин /ДВ/ - гүйцэтгэл 30%-тай. “Бүж нар” ХХК-тай гэрээ хийж, 2 удаа хөдөлгүүр нийлүүлэгдсэн боловч туршилтад тэнцээгүй учир буцааж гэрээг дүгнэсэн.
- Өөрөө буулгагч авто машин /Hyundai HD270 Dump Truck/- гүйцэтгэл 50%-тай. "Хьюндай Моторс Монгол" ХХК гэрээ хийсэн. БНСАУ-аас ачигдаж замдаа явж байна.

Их засвар, ТЗБАХ, ХО-ын нийт **БИЕЛЭЛТ 96%**

**Эрчим хүчний хэмнэлт:** 2022 оны эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр 5 бүлэг нийт 33 төрлийн 1,261.34 сая төгрөгийн ажлууд гүйцэтгэж 1,007.78 сая төгрөгийн хэмнэлт гаргасан. Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг 93,330.60 кВт.цаг буюу 8.1 сая төгрөг хэмнэсэн.

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд эрчим хүчний аудитыг 2018 онд хийлгэсэн, өгсөн зөвлөмжийн дагуу 2018-2023 оны эрчим хүч хэмнэх хөтөлбөр боловсруулан батлуулж, Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Мөн Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2022 онд эрчим хүчний хэмнэлтийн аудит хийлгэсэн.


“Уур ус, Дотоод хэрэгцээний ЦЭХ-ийг хэмнэх аян”-г 2 болон 10 саруудад цехүүдийн дунд 2 удаа зохион байгуулж нийт ахуйн болон бохир усаар 3006 тн ус буюу мөнгөн дүнгээр 6,7 сая төгрөг, ЦЭХ – ээр 1,147,3 кВ.ц мөнгөн дүнгээр 0,093 сая төгрөг хэмнэсэн.

Үйлдвэрийн хэмжээнд шинэ бүтээл ашигтай загварын төлөвлөгөө гарган батлуулж гүйцэтгэлийг жилийн эцэст дүгнэж ШБАЗ-ын аваргаар Цахилгаан цехийн засварын слесарь Г.Гантөмөр шалгарч 1.2 сая төгрөгөөр шагнуулав.

Цехийн нийт ажилтан, ИТА нарт эрчим хүч хэмнэлтийн хууль тогтоомжийг сурталчилах, "Эрчим хүч хэмнэх аргууд" сэдвээр цахим болон дотоод сүлжээ ашиглан сургалтууд хийсэн.

**Хуучин сэлбэг сэргээн засварлах, хаягдал материал ашиглаж хэмнэлт гаргах аян:** Аяныг 2022.02.15-наас 1 сар 15 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулсан. Аяны хүрээнд цехүүд идэвх санаачилга гарган, удирдлага зохион байгуулалтын өндөр төвшинд оролцож, засварлаж буй тоног төхөөрөмж, сэлбэг материалыг өдөр тутам хяналтын инженерүүдээр хянуулж, зурагжуулан баталгаажуулж ирсэн. Энэ хүрээнд гаднаас өндөр үнээр авдаг, олдоц багатай хаалт, хөдөлгүүр, насос, ролик бусад тоноглолуудыг сэргээн засварласан.

Компани нь сэргээн босголтын аяныг жил бүр уламжлал болгон явуулж засварын инженерүүд болон засварчдынхаа хөдөлмөрийг үнэлэн урамшуулж, байгууллагын тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж, зах зээлийн өртгөөр 153.79 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сэлбэг материалыг сэргээн засварлаж зардлыг бууруулж ажилласан. Идэвх санаачлагатай оролцсон инженер, засварын бригадын бүрэлдэхүүнийг хэмнэлтийн нийт дүнгийн 3,1 хувь буюу 4.8 сая төгрөгөөр шагнаж урамшуулав.



Аваар, саатал, доголдлын үзүүлэлтийг 5 жилээр хүснэгтээр харуулав.

№	Он	Аваар	I зэргийн саатал	II зэргийн саатал	Доголдол
1	2018 он	-	-	2	4
2	2019 он	-	-	2	11
3	2020 он	1	-	1	8
4	2021 он	-	-	1	3
5	2022 он	-	-	2	11

Дээрх гарсан технологийн зөрчлийн саатал, аваарийн талаар ажилтнуудад зааварчилгаа өгч, авагдах арга хэмжээний талаар төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

### III. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР:

**Нийт орлого:** 2022 оны тодотгосон төлөвлөгөөгөөр 59,663.2 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 62,860.3 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 3,197.0 сая төгрөгөөр буюу 105.4 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. Үүнд:

- Цэвэр борлуулалт 3,147.9 сая төгрөгөөр,
- Үйл ажиллагааны бус орлого 49.1 сая төгрөгөөр давж биелсэн.

ЦЭХ-ний борлуулалт: Нийт 50,430.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн ба үүнээс “ДҮТ” ХХК-д 49,930.4 сая төгрөгийн (спотоор 24.6 сая төгрөг) борлуулалт хийсэн.

ДЭХ-ний борлуулалт: Орхон аймгийн нийт 319 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ хийн ажиллаж байна. 2022 онд 10,913.0 сая төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөөг 311.6 сая төгрөгөөр давуулж, 102.9 хувийн биелэлттэй ажиллав. Нийт борлуулалтын орлогын 26.1% буюу 2,850.5 сая төгрөгийг өөрийн эзэмшлийн шугамаар, 73.9% буюу 8,062.4 сая төгрөгийн борлуулалтыг “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн шугамаар дамжуулан хийсэн байна.

**Нийт зардал:** Нийт 70,948.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 66,192.2 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөнөөс 4,756.2 сая төгрөг хэмнэж ажилласан.

**Ашиг алдагдал:** Тайлант хугацаанд тодотгосон төлөвлөгөөгөөр 11,285.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас 3,661.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, тайлант үеийн батлагдсан төлөвлөгөөт алдагдлыг 7,623.6 сая төгрөгөөр бууруулж ажиллалаа. Борлуулалтын орлогыг 3,147.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, зардлыг 4,580.8 сая төгрөгөөр бууруулан, үйл ажиллагааны бус ашгийг 224.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна.он Тайлант жилд "Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар"-т ногдуулалт болон төлөлтгүйгээр, татварын дараахи алдагдал 3,661.6 сая төгрөг байна. Хойшлогдсон татварын зардалд 329,6 сая төгрөг бүртгэгдсэн. Энэ нь Сангийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 22 ны өдрийн 144 дугаар тушаалын дагуу Санхүү болон Татварын тайлангийн суурийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах аргачлалын дагуу бүртгэлд тусгагдсан элэгдлийн тайлагнал юм.

**Авлага:** 2022 оны эцэст авлага 3,600.0 сая төгрөг байгаа нь оны эхнээс 2,109.1 сая төгрөгөөр, зорилтоос 2,507.6 сая төгрөгөөр бууруулан ажилласан.

Авлага	Оны эхэнд	Зорилтот түвшин	Тайлангийн эцэст	Зөрүү оны эхнээс	Зөрүү зорилтоос	Хувь
ЦЭХ	5,417.5	5,767.8	2,415.4	(3,002.1)	(3,352.4)	67.1%
ДЭХ	288.0	329.8	256.3	(31.8)	(73.5)	7.1%
Хувь хүмүүс	2.9	2.0	1.8	(1.1)	(0.2)	0.1%
Дансны авлага	0.6	8.0	926.5	925.9	918.5	25.7%
Бүгд	5,709.1	6,107.6	3,600.0	(2,109.1)	(2,507.6)	100%

Нийт авлагын 67.1 хувийг эзэлж байгаа ТҮОНД-аас авах цахилгаан эрчим хүчний авлага нь оны эхнээс 3,002.1 сая төгрөгөөр буурсан. Дулааны эрчим хүчний авлага оны эхнээс 31.8 сая төгрөгөөр буурсан.

**Нийт өр төлбөр:** Тайлангийн эцэст 13,661.7 сая төгрөг болж, оны эхнээс 6,842.0 сая төгрөгөөр нэмэгдэж, зорилтоос 154,999.7 сая төгрөгөөр буурсан.

Өглөг	Оны эхэнд	Зорилтот түвшин	Тайлангийн эцэст	Зөрүү оны эхнээс	Зөрүү зорилтоос	Хувь
Богино хугацаат өр төлбөр	2,712.9	22,526.1	12,264.3	9,551.4	(10,261.8)	89.8%
Дансны өглөг	2,360.4	22,376.1	12,155.8	9,795.4	(10,220.3)	89%
Урьдчилж орсон орлого ДЭХ	352.5	150.0	108.5	(244.0)	(41.5)	0.8%
Орлогын аргын бүртгэлээр				-	-	-
Урт хугацаат өр төлбөр	4,106.8	146,135.3	1,397.4	(2,709.4)	(144,737.9)	10.2%
<b>Бүгд</b>	<b>6,819.7</b>	<b>168,661.4</b>	<b>13,661.7</b>	<b>6,842.0</b>	<b>(154,999.7)</b>	<b>100%</b>

Дансны өглөг буюу бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг 12,155.8 сая төгрөг байна. Үүнд: Шарын гол 2,540.6 сая төгрөг, Нутгийн буян ХХК 1,578.4 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 2,056.1 сая төгрөг, СММ ХХК 2,081.9 сая төгрөг, Содмонгол групп ХХК 163.4 сая төгрөг, Новотех интернэшнэл ХХК 159.7 сая төгрөг, бусад богино хугацаат өглөгт 1,834.1 сая төгрөг, захиалагчийн хяналт чанарын баталгаанд 393.2 сая төгрөг, татварт 500.1 сая төгрөг тус тус байна.

**Урьдчилж орсон орлого:** ДЭХ-ний урьдчилж орсон орлого 108.5 сая төгрөг (Эрдэнэт ус ДТСОНӨХК 99.6 сая төгрөг)

**Урт хугацаат өр төлбөр:** Зорилтоос 155.0 тэрбум төгрөгөөр бага байгаа нь өргөтгөлийг орлогод авч, өглөг үүсгэж бүртгэхээр төлөвлөсөн ба бүртгэлд аваагүй байгаатай холбоотой болно.

Хойшлогдсон орлогоор бүртгэсэн улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын үлдэгдэл өртөг 1,397.4 сая төгрөг байна.

#### **IV. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

Жилийн дүнгээр 76 удаагийн худалдан авалтын гэрээ байгуулан ажилласнаас, гэрээний хэрэгжилт 93.5%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжсэн, гэрээтэй холбоотой ноцтой зөрчил, маргаан гараагүй байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар 33 төрлийн 8,306.0 сая төгрөгийн, харьцуулалтын аргаар 22 төрлийн 970.3 сая төгрөгийн, гэрээ шууд байгуулах аргаар 11 төрлийн 290.6 сая төгрөгийн, шууд худалдан авалтаар 65 төрлийн 577.1 сая төгрөгийн нийт 9,996.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авч худалдан авах төлөвлөгөөний биелэлт 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2022 онд дотоодын 25 үйлдвэрлэл эрхлэгчдээс 946.6 сая төгрөгийн чанар, стандартын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулан 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

## 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний биелэлт


№	Тендер шалгаруулалтын журам /арга/	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хувь	Хэмнэлт /сая.төг/
		Төсөв /сая.төг/	Тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Тоо		
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	8,306.0	33	8,225.4	33	94.8%	80.6
2	Харьцуулалтын арга	970.3	22	966.5	22	100%	3.7
3	Шууд гэрээ байгуулах арга	290.6	11	252.6	11	96.4%	38.0
4	Шууд худалдан авалт	577.1	65	551.8	65	100%	25.2
<b>Нийт дүн</b>		<b>10,144.0</b>	<b>131</b>	<b>9,996.4</b>	<b>131</b>	<b>97.7%</b>	<b>147.6</b>

Тус компанийн 2022 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд 131 төрлийн 10,144.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 9,996.4 сая төгрөгийн худалдан авалт хийж, 147.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.

### V. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Монгол улсын хэмжээнд болон компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмын эрх зүйн хүрээнд дотоод хяналт, шалгалтыг зохион явуулахдаа байнгын болон төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус удирдамжит үзлэг, шалгалтыг зохион байгуулж, тайлан, дүгнэлт, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулан, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг хийж, зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:



2022 онд хөдөлмөр хамгааллын хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон бусад зардалд 374.2 сая төгрөгийг зарцуулж, ХАБЭА-д зарцуулах зардлыг жил тутам өсгөн нэмэгдүүлэхэд анхаарал тавин ажиллаж байна.

Өдөр тутам бүх ажлын байруудаар эргэлт, шалгалтыг зохион байгуулж, ТАД, ААД, наряд, шийдвэрийн системийн мөрдөлт, эрсдлийн үнэлгээний хэрэгжилтэд байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүрд нь устгуулж, ажилласнаар хүний буруутай осол, саатал гарахаас урьдчилан сэргийлж, 2022 онд компанийн хэмжээнд 1555 наряд, 6512 шийдвэрээр ажил гүйцэтгэж, осол, аваригүй ажилласан байна.

ХАБЭА-н I, II, III шатны үзлэг хийсэн байдалд хяналт тавин, илэрсэн зөрчил, дутагдлыг устгуулах, дүгнэлт хийх, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллав. Тайлант хугацаанд:

- Анхан шатны үзлэг 4954 удаа

- II шатны үзлэг нийт 162 удаа
- III шатны үзлэг удирдамжийн дагуу 4 удаа хийгдсэн байна.

Хөдөлмөр хамгааллын өдөрлөгийг 7 хоног бүрийн лхагва гаригт төлөвлөсөн сэдвийн дагуу хийж, илэрсэн зөрчлүүдийг дор бүр нь устгуулж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав. Нийт 53 удаагийн өдөрлөг хийгдэж, давхардсан тоогоор 1656 ИТА, 5965 ажилтан оролцсон байна.

Ажлын байрны эрсдлийн түвшин тогтоов: Хөдөлмөрийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/295 тоот тушаалыг үндэслэж, эрсдлийн үнэлгээг хийх аргачилсан зөвлөмжийн дагуу эрсдлийн үнэлгээний аргачлал боловсруулж, нэг загварын журнал болгон хэвлүүлж, цех бүрийн ажлын онцлогт тохирсон эрсдлийн үнэлгээ хийгдэж, ажилбар болгоны эрсдлийг үнэлэн, бууруулах үйл ажиллагааг байнга хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн, найдвартай ажиллагааг ханган, осол, аваарьгүй ажилласан. 2022 онд нийт 493 ажилбарт эрсдлийн үнэлгээ хийгдсэн байна. Жил бүр эрсдэл буурсан болон шинээр бий болсон ажлын байранд дахин үнэлгээг хийн, баяжуулж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих хамт олны хяналтыг өндөржүүлж, илэрсэн аюул, эрсдэл, зөрчлийг устгах ажлыг оновчтой зохион байгуулж, хөдөлмөрлөх ая тухтай, эрүүл, эрсдэлгүй орчинг бүрдүүлэхэд хамт олны идэвх, санаачилгыг өрнүүлэх зорилгоор “Аюул, эрсдэлгүй ажиллагч хамт олон” болзолт уралдааныг 5 дэх жилдээ зохион байгуулж, 2022 оны “Шилдэг хамт олон”, “Шилдэг аюулгүй ажиллагч ажилтан”-ыг тус тус шалгаруулан, шилжин явах цомыг гардууллаа.

Цахилгаан болон дулаан-механикийн тоног төхөөрөмжид үзлэг, үйлчилгээ хийх, технологийн болон засвар, угсралт, туршилт, тохируулгын ажлыг наряд, шийдвэрийн дагуу гүйцэтгэх үед тоног төхөөрөмжийг эрчим хүчний бүх төрлийн аюултай эх үүсвэр, хорт бодисын эх үүсвэрээс тусгаарлаж, ажилтныг осол, эрсдэлгүй ажиллуулахын тулд 2022 онд цоож, пайзны системийн журмыг боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн ажиллаж байна.



“Өглөөний ХАБ” сэдэвт үйл ажиллагааг эхлүүлж, нэгж бүрийн ажилтнууд ээлж дараагаар ААД, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, аюул, ослоос



урьдчилан сэргийлэх чиглэлээр зааварчилгаа, мэдээлэл бэлтгэн, ажилд гарахын өмнө 5-10 минутын хугацаанд нэгжийн хамт олондоо танилцуулж, мэдлэгээ бататган ажиллаж байна.




### 2022 онд бидний гаргасан амжилт:

- Орхон аймгийн хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Шилдэг байгууллагаар шалгарч, дурсгалын цом, мөнгөн шагналаар шагнуулав.
- “Ажлын байрны аюул, эрсдэл - удирдлагын манлайлал” сэдэвт илтгэлийн уралдаанд ХАБЭА инженер Д.Бямбадулам, Э.Отгон-Эрдэнэ нар оролцож, тэргүүн байрыг эзлэв.
- “Ажилтны аюулгүй байдал, асуудал, шийдэл” онол практикийн бага хурлын илтгэлийн уралдаанд ХАБЭА инженер Д.Отгонбат, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Н.Дуламсүрэн нар оролцож, гутгаар байрыг эзлэв.



**Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр:** Байгууллагын “Эрчим” саам сувилалын газарт 2022 оны 6,7,8 дугаар саруудад 55 ажилтан, 29 ахмад ажилтан, 137 гэр бүлийн гишүүдийг амрааж, эрүүл мэндийг дэмжиж ажилласан. Сувилалын хөнгөлөлтийн зардалд нийт 15.9 сая төгрөг зарцуулсан.



Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нарын багаар 369 ажилтнуудад эрүүл мэндийн хугацаат үзлэг хийлгэсэн. Үзлэгт нийт 41.2 сая төгрөг зарцуулсан.

Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлж 67 ажилтаныг чих, хамар, хоолойн өвчлөлийг илрүүлэх үзлэгт хамруулав. “Эрхэс Оргил” эмнэлгийн эмчээр 217 ажилтанд чих, хамар, хоолойн үзлэг, сонсголын бичлэг, эмчилгээ хийлгэсэн. Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр 43 ажилтаныг 5 хоногийн эмийн эмчилгээнд хамруулсан.



Оношилгоо, эмчилгээнд нийт 2.0 сая төгрөг зарцуулсан. Алба, хэлтэс, цехүүдийн ажилтнуудад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулсан.



“Орхон эм хангамж”, “Органик” эмийн сангуудтай хамтран 113 ажилтнуудыг эрдэс, амин дэмийн оношилгоонд үнэ төлбөргүй хамруулж, ажилтнуудын биеийг дархлаажуулах ажлыг зохион байгуулсан.

“Мөнх-Сүндрэл” өрхийн эмнэлэгтэй хамтран томуугийн халдвараас сэргийлсэн вакцинжуулалтанд 52 ажилтаныг хамруулсан. Орхон аймгийн Эрүүл мэндийн газартай “Эрүүл зөв хооллолт”, “Хоол боловсруулах замын эмгэг”-ийн тухай сургалт, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд өглөөний алхалт, өглөөний дасгал, бүжгийн сургалтыг тус тус зохион байгуулсан.




Улаан загалмайн хороотой хамтран “Анхны тусламж, амь нас аварна” сургалтыг зохион байгуулж, шинэ ажилтнуудад яаралтай үед анхны тусламж үзүүлэхэд сургасан.

Спорт заал, фитнес, теннис, саун, эмэгтэйчүүдийн танхимуудад ажилтнуудыг тогтмол хичээллүүлж, чийрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан.



**Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр:** Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн байгууллагаар 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 19 ажлын байранд орчны хэмжилт хийлгэсэн. Үүнд: нарийн ширхэгтэй тоос, аммиак, цахиурын давхар исэл, агаарын урсгалын хурдыг хэмжүүлсэн. Нийт зардалд 999.0 мян төг зарцуулсан.



Үйлдвэрийн ажлын болон ахуйн байруудад сар бүр, лабораториудад улирал бүр орчны хэмжилтийг хийж, илэрсэн зөрчлийг хариуцсан инженер, ХАБЭА инженерүүдэд танилцуулж зөрчлийг устгуулж ажилласан.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ТЭЦ-4 инженерүүдтэй хамтран байгууллага дээр хэмжилт хийж, туршлага судалсан.



- Эрүүл мэндийн хугацаат үзлэгийг 391 ажилтнуудад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв”-ийн эмч нарын багаар хийлгэсэн.
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлж 217 ажилтныг чих, хамар, хоолойн өвчлөл, сонсгол бууралтыг оношлох үзлэг, эмчилгээнд хамруулсан.
- “Органик” эмийн сантай хамтран ажилтнуудыг эрдэс, амин дэмийн оношилгоонд үнэ төлбөргүй хамруулж, дархлаажуулсан.
- “Мөнх-Сүндрэл” өрхийн эмнэлэгтэй хамтран томуугийн халдвараас сэргийлсэн вакцинжуулалтанд 52 ажилтаныг хамруулсан.
- Байгууллагын “Эрчим” саам сувилалд 55 ажилтан, 29 ахмад ажилтан, 137 гэр бүлийн гишүүдийг сувилсан.
- БОЭТ-д эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 63 ажилтныг хамруулсан.

**Дотоод аудитын чиглэлээр:** 2022 оны жилийн ажлын төлөвлөгөөний дагуу дотоод аудитын ажлын хөтөлбөр боловсруулан ажиллаж дүгнэлт гарган, зөвлөмж өгч гүйцэтгэлийг хангуулан ажиллав.

2021 оны жилийн эцэс, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан, Компанийн өөрийн эзэмшлийн агуулахуудад ээлжит бус үзлэг шалгалт, 3-р улирлын байдлаарх Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, ТЗБАХ, их засварын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гарган зөвлөмж өгч ажиллав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах 5 заалттай төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг гаргасан. Компанийн санхүүгийн тайлан мэдээллийг шилэн дансны цахим хуудас, компанийн ил тод мэдээллийн самбар, <https://erdenetpp.mn/> цахим хаягт хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна. 2022 онд орхигдуулсан, хоцроосон мэдээлэл байхгүй, мэдээллүүдийг бүрэн байршуулсан.

Шилэн дансны улирал бүрийн тайланг илгээж хагас бүтэн жилийн дүн, тайланг ЭХЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлж ажиллав.

**Хэмжил зүйн чиглэлээр:** Хими, Цахилгаан, ДХХА цехүүдийн лабораторийн итгэмжлэлийн материал, чанарын гарын авлагыг ISO 17025:2018 стандартын дагуу шинэчлэн боловсруулж, СХЗГ-т хүргүүлж лабораториудийн итгэмжлэлийн эрхийг 3-5 жилээр сунгуулав.

СХЗГ-тай байгуулсан гэрээний дагуу ДХХА, Цахилгаан, Хими цехүүдийн эталон хэмжүүрүүд, суурин төхөөрөмжүүдийг 100 хувь улсын шалгалт баталгаажуулалтанд хамруулав.

Орхон аймгийн хэмжээнд 355 байгууллагын 359 дулааны тоолууртай болж байна. Тоолуурын насжилт ихсэж байгаатай холбоотойгоор хяналт шалгалт хийх шаардлага ихсэж, 2022 онд давхардсан тоогоор 7 хоногт 1-3 удаа, жилд давхардсан тоогоор 75-аас дээш удаа ДЭХ-ний хэрэглэгчдэд хяналт шалгалтыг зохион байгуулав.

**Байгаль орчны чиглэлээр:** БОАЖС-ын 2019 оны А/618 тоот тушаалын дагуу 2022 оны БОМТ-г шинэ загвараар гаргаж батлуулан, тусгагдсан ажлуудыг 100% ханган биелүүлж, Орхон аймгийн байгаль орчны зөвлөлд 2022 онд хийсэн ажлын тайланг танилцуулан хамгаалж, 96 оноо буюу хангалттай сайн үнэлгээ авсан.

2022 оны БОМТ-ний дагуу Орхон аймгийн УЦУОШТ-тэй 2 жилийн гэрээ хийж ус, агаар, хөрсний шинжилгээ хийлгэн хяналт тавин ажиллаж байна.

Нүүрсний тоос сууршлийн бүс рүү хийсэхээс сэргийлж 2022 онд компанийн хашааны араар 100ш мод тарьж ургуулсан.

Орхон аймгийн УЦУОШТ-өөр хөрс, агаар, усны шинжилгээ хийлгэхэд стандарт хэмжээндээ гарсан

Ажиллаж байгаа зуухнуудад сар бүр агаар мандалд утааны хийн найрлагатай хамт хаягдах хүхрийн давхар исэл SO<sub>2</sub>, азотын давхар исэл NO<sub>x</sub>, нүүрстөрөгчийн

давхар исэл СО-г сар бүр хэмжилт хийлгэн улирал бүр тайланг авч хяналт тавихад стандартаас доогуур гарсан.

Ашиглаж байгаа үнсэн сангийн далангийн дэргэд урьдчилан сэргийлэх зорилгоор үнсэн сангаас шүүрэлт гарсан тохиолдолд Эрдэнэт голыг бохирдуулахаас хамгаалах зорилгоор ус цуглуулах худаг хийлгэж ашиглалтанд оруулсан. Худагт ус хуримтлагдсан тохиолдолд үнсэн сангийн далан руу буцааж хийх схем хийсэн.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 1000 ширхэг мод үнсэн сангийн дэргэд Эрдэнэт голын дагуу хашаалж тарьсан.

Компанийн хашаан дотор ашиглагддаггүй байсан 500 м.кв талбайд модны үрсэлгээний газар байгуулж 4535 ширхэг бургасны үрсэлгээ хийж 90-95 хувийн ургалттай 1,2-1,8 метр өндөр ургасан. Ирэх жилийн мод тарилтаар үрсэлгээ гаднаас худалдаж авахгүй нөхцөл бүрдүүлсэн.



Ажиллаж байгаа зуухнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд горимын хэсэг байнгийн хяналт тавьж үнс баригчийн ажиллагааг хянаж, зуух галлах болгонд горимын карт тавьж ажиллав.

Галын аюулгүй байдал, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр: Алба, хэлтэс, цех, хэсгүүдийн гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гадуур болон дотуур усан хангамж, галын насос станц, галын усны шугам, галын усны хаалтууд, тоосролтой ажлын байрууд, тоосон системийн төхөөрөмжүүдэд тогтмол хяналт шалгалт хийж, цэнэглэх шаардлагатай 22 ширхэг MFZ маркийн гал унтраагуурыг цэнэглүүлж, гал унтраах бэлтгэл бэлэн байдлаа хангуулж ажилласан.

Компанийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөболон албаны төлөвлөгөөг шинэчилсэн загварт оруулж, алба, мэргэжлийн ангийн бүлгүүдийг томилгоожуулан гүйцэтгэх захирлын тушаал гаргуулан батлуулж, хүн хүч, техник хэрэгслүүдийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллалаа.

Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Шинэ жил”, “Цагаан сар”, “Усан хангамж”, “Ой хээрийн түймрийн бүлгүүдийн бэлтгэл бэлэн байдал”, “Үерийн далан суваг шуудуй”, “Гүйцэтгэх захирлын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг” зэрэг 7 удаагийн нэгдсэн удирдамжит арга хэмжээ зохион байгуулж ажилласан.

364 зөрчил илрүүлж, 254 зөрчлийг нь газар дээр нь арилгуулж, үлдсэн 118 зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-22, мэдэгдэл-26 тус тус хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Хууль эрх зүйн чиглэлээр: Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журмын дагуу 28 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан. 5 ажилтанг ажлаас халж, 2 ажилтанд албан тушаал бууруулах, 7 ажилтанд үндсэн цалинг 3 сар 20 хувь хүртэл бууруулах, 2 ажилтанд үндсэн цалинг 1 сар 20 хувь хүртэл бууруулах, 12 ажилтанд нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэйсануулах, арга хэмжээг тус тус авсан.

Компанийн ёс зүйн зөвлөлд 1 өргөдөл ирснийг “Ажилтнуудын ёс зүйн дүрэм”-ийн дагуу шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажилласан.

Нийт ажилтнуудад “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Хамтын гэрээ хэлэлцлээр, хэлцэл хийх”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Ажилтнуудын ёс зүйн дүрэм”, “Зөрчлийн тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Замын хөдөлгөөний дүрэм” “Эрүүгийн хууль”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хууль”, Насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлэх талаарх хууль, эрх зүйн сургалтуудыг зохион явуулж, Орхон аймгийн замын цагдаагийн газраас ирүүлсэн “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ аян”-д компанийн нийт ажилтнууд сайн дураараа нэгдэж, аяныг зохион байгуулан хэрэгжүүлэв.

## **VI. АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫН ТАЛААР**

Үндсэн үйлдвэрлэлийн ажилтнуудын нийгмийн зардал: 2022 онд Үндсэн үйлдвэрлэлийн АНЗ-д 2,151.9 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 1,684.2 сая төгрөг зарцуулж 467.7 сая төгрөг хэмнэсэн байна. Үүнд:

- Тэтгэвэр тэтгэмжид: 1,142.9 сая төгрөг төсөвлөж, тайлангийн хугацаанд 950.8 сая төгрөг зарцуулсан байна. Зөрүү нь хэмнэлтийн хуультай холбогдуулан 35 жилийн ойн баярт зориулсан 150 сая төгрөг зарцуулагдаагүй болно. Томоохон зардлуудаас дурдвал:
- Өндөр насны тэтгэвэрт: 24 ажилтан 927.5 сая төгрөг, 13 ажилтны ар гэрт уй гашуу тохиолдоход нийт 9.3 сая төгрөгийн буцалтгүй тусламж, жирэмсний амралттай эхчүүдэд 8 сая төгрөгийг тус тус олгосон.
- Хоолны хөнгөлөлт: Ажилтнуудын хоолны хөнгөлөлт болон түүний НДШ-д нийт 631.1 сая төгрөг төсөвлөж, 500.8 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Унааны хөнгөлөлтөд: 13.1 сая төгрөг төсөвлөж, 10.6 сая төгрөгийг зарцуулав.
- Халаалтын улирлын хөнгөлөлтөд: 53.1 сая төгрөг төсөвлөж, 53.3 сая төгрөгийг зарцуулсан.
- Эмнэлгийн зардалд: 84.5 сая төгрөг төсөвлөж, 56.1 сая төгрөг зарцуулсан байна. Томоохон зардлуудаас дурдвал: Сувиллын хөнгөлөлтөд 13 ажилтанд 1.5 сая төгрөг, саамны хөнгөлөлтөд 7 болон 8 саруудад нийт 15.7 сая төгрөг, урьдчилан сэргийлэх үзлэгт 36.9 сая төгрөг, орчны тоос хэмжилтэд 0.999 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Шагналд: 209.5 сая төгрөг төсөвлөж, 96.6 сая төгрөгийг шагналд зарцуулсан бөгөөд бусад шагналын зардлууд нь хэмнэлтийн хуулийн дагуу гэрээний дүнгийн шагнал 20 сая төгрөг, ШБАЗ-н урамшуулал 45 сая төгрөг, бүтээмжийн урамшууллын 14.5 сая төгрөг, болон бусад шагналын зардлууд тус тус олгогдоогүй болно. Томоохон зардлуудаас дурдвал:

- Тэргүүний ИТА, ШБАЗ-ын аварга болсон 2 ажилтанд 2.4 сая төгрөг,
- Оны ажил мэргэжлийн аваргуудын шагнал 13.3 сая төгрөг,
- 50 нас хүрсэн 14 ажилтанд 1 сарын үндсэн цалин буюу нийт 17.1 сая төгрөг,
- Салбарын тэргүүн, түүнтэй адилтгах шагналаар 33 ажилтанд 5.3 сая төгрөг,
- Ээлжийн ажилтнуудын уралдаанд амжилт үзүүлсэн ээлжүүдийг 11.96 сая төгрөг,
- ШБАЗ-ын урамшуулал 5 сая төгрөг

Бүтээмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 35.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Соёл олон түмний арга хэмжээ: Соёл олон түмний арга хэмжээнд 17.5 сая төгрөг төсөвлөж, 15.9 сая төгрөгийг зарцуулаад байна. Зөрүү нь хэмнэлтийн хуулийн дагуу Эрчим хүчний системийн тэмцээний 20 сая төгрөг зарцуулагдаагүй болно.

**Үйлдвэрлэлийн бус нийгмийн зардал:** 209.5 сая төгрөг төсөвлөж, 159.1 сая төгрөг зарцуулсан. Томоохон зардлуудаас дурдвал:

- Тэтгэвэр тэтгэмжид: Мэргэжлээс шалтгаалах өвчний учир группт байсан 1 хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгож, 15.3 сая төгрөг, хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тахир дутуу одой иргэн ажиллуулаагүйн төлбөр 17.1 сая төгрөг, Эх үрсийн баяр, Шинэ жилийн баяраар хүүхдүүдийн бэлэгт нийт 20.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан.
- Ахмадын сан: Ахмадын санд 117.9 сая төгрөг төвлөрүүлж, 101.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд 19 ахмадад насны ойн шагнал 1.9 сая төгрөгийг, нас барсан 3 өндөр настны ар гэрт 3 сая төгрөгийн буцалтгүй тусламж, цагаан сарын баяраар 207 ахмад, болон 3 МШӨ-ний группэд байдаг хүнд нийт 37.8 сая төгрөг, ахмадын баяраар 207 ахмадад 6.2 сая төгрөг, халаалтын улирлын хөнгөлөлт 23.3 сая төгрөг, ЭХТА цолтой өндөр настан болон МШӨ-тэй хүмүүст өгөх урамшуулалд 29.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**2022 оны Ажилчдын нийгмийн зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.**

№	Зардлын төрөл	2022 оны төлөвлөгөө /сая.төг/	2022 оны гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
<b>1</b>	<b>Үндсэн үйлдвэрлэлийн АНЗ</b>	<b>2,151.9</b>	<b>1,684.2</b>	<b>467.7</b>
1.1	Тэтгэвэр, тэтгэмж	1,142.9	950.7	192.2
1.2	Түлшний хөнгөлөлт /НДШ хамт/	53.1	53.3	(0.2)
1.3	Хоолны хөнгөлөлт	551.2	447.4	103.8
1.4	Хоолны хөн-НДШ	79.9	53.4	26.6
1.5	СОТАХ	17.6	15.9	1.6
1.6	Унааны хөнгөлөлт	13.1	10.6	2.5
1.7	Шагнал	209.5	96.6	112.9
1.8	Эмнэлгийн зардал	84.5	56.2	28.3
<b>2</b>	<b>Үйлдвэрлэлийн бус АНЗ</b>	<b>209.7</b>	<b>159.2</b>	<b>50.5</b>
	<b>Нийт</b>	<b>2,361.6</b>	<b>1,843.4</b>	<b>518.3</b>



**Биеийн тамир, соёл олон түмний арга хэмжээний хүрээнд:** Соёл олон түмний арга хэмжээнд 17.5 сая төгрөг төсөвлөснөөс 15.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Үүнд цагаан сарын баярын арга хэмжээ үхэр жилтний жилийн засалд 0.7 сая төгрөг, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтсан арга хэмжээнд 0.9 сая төгрөг, Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 0.6 сая төгрөг, ургацын баярт 0.5 сая төгрөг тус тус зарцуулагдсан байна. Монгол улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан эрчим хүчний салбарын төр,хувийн хэвшлийн байгууллагуудын дунд “Спортын их наадам”-ыг 2022 оны 9 дүгээр сарын 09-12-ны өдрүүдэд УБ хотод 6 төрлөөр зохион байгуулж явууллаа. Уг арга хэмжээнд манай компаниас 60 гаруй тамирчид оролцож, 39 байгууллагаас 12 дугаар байранд орсон.



**Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр буюу Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн дунд “Миний бахархал” сэдэвт гар зургийн уралдаан, 6-10 дугаар ангийн хүүхдүүдийн дунд “Миний бахархал” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, 0-3 насны 113 хүүхдэд бэлэг, 4-6 насны 108 хүүхдэд тоглоомын тасалбар, 7-10 насны 160 хүүхдэд жүжгийн тасалбар, 11-15 насны 172 хүүхдэд киноны тасалбар, хагас бүтэн өнчин 16 хүүхдэд 0.8 сая төгрөгийн тэтгэлэг, өрх толгойлсон 5 эцэг эхэд 0.3 сая төгрөгийн тэтгэлэг өгсөн. Уг арга хэмжээнд нийт 5.7 сая төгрөг зарцуулсан. Хамтын ажиллагаатай Орхон аймгийн УЗХ-нд хүсэлт тавьж, 1 өрхийн сарын хэрэглээгээр тооцож тус бүр 10 өрхөд 2 удаа хүнсний багц олгосон.



Ажилтнуудынхаа амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх ажлын хүрээнд 2022 оны 4,5 дугаар сард “Солонго” бүжгийн клубтэй хамтран бүжгийн дугуйлан хичээллүүлж давхардсан тоогоор 84 ажилтан хамрагдсан. Нэг удаагийн төлбөр 5000 төгрөгөөр тооцож, 2 сард нийт 1.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрсдөдөө хийсэн байна. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 60 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр “Махимус фитнесс” клубтэй гэрээг байгуулан сард тогтмол 40-45 хүн буюу жилд давхардсан тоогоор 500 гаруй ажилтныг хамруулсан байна. Үндсэн төлбөр 100,000 төгрөг бөгөөд манай байгууллагын ажилтнууд сард 40,000 төгрөг төлж байна. Спорт заал, саун, эрэгтэй эмэгтэй бялдаржуулах танхим, ширээний теннис зэргийг өдрийн цайны цагаар болон ажлын бус цагаар хуваарийн дагуу ажиллуулж, ажилтнуудаа хөдөлгөөний


дутагдлаас хамгаалах, таргалалтаас урьдчилан сэргийлэх талаар анхаарч ажиллалаа.



**Сайн үйлсийн аян:** Турбин цехийн ахмад ажилтан У.Эрдэнэтуяагийн эмчилгээнд 4.5 сая.төгрөг,

- Цахилгаан цехийн ажилтан Б.Эрдэнэхүүгийн хүүхдийн эмчилгээнд 5.4 сая.төг
- ТДЦехийн ажилтан Б.Гомбосүрэнгийн эмчилгээнд 5.1 сая төгрөг,
- Турбин цехийн ажилтан Б.Болдын гэр шатахад 3.5 сая төгрөгийн хандивын аяныг тус тус хамт олноороо зохион байгуулсан.

**Сургалт хөгжүүлэлтийн чиглэлээр:** 2022 онд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг 7 төрлийн 47 заалт бүхий арга хэмжээнд 80.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 102.0 сая төгрөгийг зарцуулсан.



2020-2021 онуудад цар тахлын улмаас байгууллага дээр зохион байгуулагдах гадаад, дотоодын сургалтуудыг цуцалж, хувь хүн, ажилтанд чиглэсэн мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан бол 2022 онд нийт ажилтнуудад чиглэсэн сургалтуудыг түлхүү зохион байгуулснаар сургалтын зардал хэтэрч гарсан. Үүнд: хүний нөөцийн бодлогын бичиг баримт боловсруулах суурь зарчим, судалгаа, арга зүй болон монголын ЭХ-ний барилга засварчдын холбооноос зуухан цехийн ажилтнуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулсан байна. Зохион байгуулагдсан сургалтууд:


- Байгууллага дээр мэргэжлийн чиглэлийн техникийн хичээлүүд, дулаан механикийн тоноглолд ажиллах ААД, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, гамшгийн тухай хууль, эмнэлгийн анхны тусламж, ХАБЭА-н хууль, аюул эрсдэл, цахилгаан тоноглолын аюулгүй ажиллагааны группийн ангилал, шинэчилсэн хөдөлмөрийн хууль, дүрмийн сургалтуудад нийт давхардсан тоогоор 976 ажилтан.
- Эрх бүхий байгууллагатай хамтарсан нийт ажилтны ХАБЭА-н сургалтыг 2019 оны ХНХСайдын А/370 тушаалын дагуу 6 чиглэлээр давхардсан тоогоор 455 ажилтан.
- ШУТИС болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулж байгаа дулаан, цахилгааны засвар ашиглалтын инженер, мастер, засварчны мэргэжил дээшлүүлэх сургалт, бичиг баримт боловсруулах, үйлдвэрлэлийн автоматжуулалт, программчлагдах логик контроллер давтамж хувиргуур, мэдээллийн аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад 26 ажилтныг, замчин, туслах машинч, найруулагч, зүтгүүрийн машинч бэлтгэх, мэргэжил олгох сургалтад төмөр замын 14 ажилтнуудыг хамруулж, нийт давхардсан тоогоор 1471 ажилтанд 102.0 сая төгрөгийг зарцуулсан.



**Уралдаан тэмцээн:** Монгол улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК байгуулагдсаны 35 жилийн ойн баярыг тохиолдуулан САЗЗ, цол зэрэгтэй ИТА нарын зөвлөлөөс инженер техникийн ажилтнуудын дунд “Техникийн хичээлийн шилдэг гарын авлага” боловсруулах уралдааныг ажлын байр бүрт сургалтын ном товхимол, заавар, видео хичээлтэй

болох зорилгоор өрнүүлэв. Уралдааны удирдамжийн дагуу нийт 18 ИТА нарын 17 сэдвээр боловсруулагдсан гарын авлагын материалууд ирсэн байна.

Боловсон хүчний хувьд нэг үе солигдож, шинэ залуу ажилтнууд орж ирж байгаатай холбогдуулан шинэ ажилтнуудыг ажлын байран дээр сургаж, дадлагажуулах, ахмад ажилтнуудын туршлагыг өвлүүлэх зорилгоор цахилгаан цехийн хамт олны дунд ажил мэргэжлийн уралдааныг зохион явуулав.



**Бүтээмжийн чиглэлээр:** Бүтээмжийн ажлын хүрээнд техник технологи сайжруулах, зардал бууруулах, ажлаа хөнгөвчлөх, эрсдэл бууруулах чиглэлээр нийт 40 гаран “Кайзен санал” гаргаж, аюулгүй ажиллагаа хангасан, материал сэлбэг хэмнэж хэмнэлт гаргасан, ажлын нөхцөл сайжирсан, хугацаа хэмнэсэн, шинэ технологи сайжруулалт нэвтэрсэн, багаар ажиллах ажиллагаа сайжирсан, бүтээлч сэтгэлгээ нэмэгдсэн 400 гаран ажлыг гүйцэтгэж, 64 ажил дээр төсөл хамгаалан 4.1 сая төгрөг, хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор станцын хэмжээний ач холбогдолтой тухайн үеийн шаардлагатай төсөл санхүүжүүлэхэд 18.4 сая төгрөг зарцуулсан байна. Мөн технологи сайжруулах, хөдөлмөрөө хөнгөвчлөх чиглэлээр “Шилдэг төсөл” шалгаруулах 2 сарын хугацаатай үргэлжлэх 2.4 сая төгрөгийн урамшууллын сан бүхий уралдаан зарлаж дүгнэв. Ажлын болон ахуйн байрнуудын ажиллах нөхцөл, тав тухтай байдлыг хангах чиглэлээр 11 ажлын байр “Ажлын байрны соёл-5С” болзол хангасан байна.

Чанарын дугуйлангуудын уралдаан болон “Мэдлэг хуваалцах өдөрлөг”-ийг 3 удаа зохион явуулж үр дүн сайтай ажлууд, хамт олныг урамшуулах, сурталчлах ажлуудыг зохион байгуулж байна. 2022 онд бүтээмжийн урамшуулалд 50.0 сая төгрөг төлөвлөснөөс 32.2 сая төгрөг зарцуулж, 64%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2023 онд бүтээмжийн ажлын урамшуулалд 30 сая төгрөг, “Чанарын удирдлагын болон ХАБЭА-н удирдлагын ISO-9001,45001 тогтолцоо”- г нэвтрүүлэх ажилд 40 сая төгрөг төлөвлөн ажиллаж байна.

**Бүтээмжээр хийгдсэн томоохон ажлуудаас:**

1. Сургалтын зориулалтаар БК3-75-39 зуухны макет бүтээх, суурилуулах ажил



## 2. Вагон хөмрөгчийн галерейд вагоноос сорьц авах тавцан



3. Өргөтгөлөөр суурилуулсан вакум насос таслалт хийх схем

шинээр №1,2-д

4. Станцын "Эрчим саам" амралтын газарт ажиллагсдыг тав тухтай амрах, эрүүл мэндээ сайжруулах нөхцөлийг хангав.



**Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр:** Нийт ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад 2022 онд 25.2 сая төгрөгийг зарцуулж ажилласан.



Мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үзлэгийг нарийн мэрэгжлийн эмч нар 365 ажилтан, 17 ахмад ажилтанд эрүүл мэндийн үзлэгт хамруулахад 14.5 сая төгрөг, химийн хортой бодистой харьцаж

ажилладаг 33 ажилтныг элэг, бөөрний үйл ажиллагаа үнэлэх цусны шинжилгээнд хамруулж 1.2 сая төгрөг, 257 ажилтанд чих, хамар, хоолойн өвчний илрүүлэг, сонсголын бичлэг хийж, шаардлагатай ажилчдад 10 хоног эмчилгээ хийлгэж 2.0 сая төгрөг, эмийн болон нөхөн сэргээх физик эмчилгээг 202 ажилтанд хийж эрүүл мэндийг дэмжиж ажилласан.

Улсын клиникийн 3-р эмнэлэгт уушигны компьютер томографийн шинжилгээнд асбесттай харьцаж ажилладаг 2 ажилтныг хамруулсан.

Мэргэжлээс шалтгаалах үндэсний төвд хөгжлийн бэрхшээлтэй 5, архаг суурь өвчтэй 2 ажилтаныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Бамбай эмийн сантай хамтран хеликобактери, ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх, дархлал дэмжих витамин зөв хэрэглэх тухай мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, ажилтнуудыг ясны сийрэгжилт, хеликобактери тодорхойлох шинжилгээнд хамруулсан.

Алба, хэлтэс, цехүүдийн ажилтнуудад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай мэдлэг олгох сургалт явуулсан.

### **VIII. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:**

2022 оны 4 дүгээр сарын 29 өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан. Хэмнэлтийн хуулийн дагуу хийгдсэн зарим ажлуудаас дурдвал:

- Хуулийн 5.1 дэх заалтын дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 20 тоот тогтоолоор санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал, үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер, аж ахуй эрхэлсэн дэд захирал 3 орон тоо хасаж 60.6 сая төгрөг хэмнэсэн.
- Хуулийн 6.1 дэх заалтын дагуу Гүйцэтгэх захирал Орхон аймагт ажлын шаардлагаар жижиг тэрэг ашиглаж байна. Ерөнхий инженер, Ерөнхий нягтлан бодогч нарын автомашины хэрэглээг 2022 оны 4 дүгээр сарын 01-ээс хязгаарлан, төлөвлөгөөнд тодотгол оруулан төлөвлөсөн зардлыг хассанаа 5.9 сая төгрөг хэмнэв.
- Хуулийн 12.1.1 дэх заалтын дагуу 47 ажилтны гар утасны хөнгөлөлтийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ээс хязгаарлан, төлөвлөгөөнд тодотгол (ЭХС-н 2022.06.08-ны А/127) оруулан төлөвлөсөн зардлыг хассан. 7.6 сая төгрөг.
- Хуулийн 13.1.3 дэх заалтын дагуу ИЗ, ТЗБАХ, ХО-ийн төлөвлөсөн зардлаас хэмнэгдсэн зардал болох 247.0 сая төгрөгийг өөр төсөл арга хэмжээнд зарцуулаагүй.
- Хуулийн 15.1.3-д заасны дагуу төлөвлөгөөнд тодотгол (ЭХС-н 2022.06.08-ны А/127) оруулан төлөвлөсөн зардал болох орон сууцны хөнгөлөлт 200.0 сая төгрөг, ЭХСалбарын 100 жил, Компанийн 35 жилийн ойн арга хэмжээний 100.0 сая төгрөг, спортын арга хэмжээний 20.0 сая төгрөгийг хассан.
- Хуулийн 15.1.4-д заасны дагуу төлөвлөгөөнд тодотгол оруулан компани сурталчлах бэлэг дурсгалын зүйлийн зардал 10.0 сая төгрөгийг хассан.
- Хуулийн 15.2.3-д заасны дагуу сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилот болон холбогдох бусад зардлыг хэмнэхээр зорилт тавин ажилласан. Гадаад сургалтын 14.0 сая төгрөгийг төлөвлөгөөнд тодотгол (ЭХС-н 2022.06.08-ны А/127) оруулан хассан.

- Хуулийн 15.2.4-д заасны дагуу бичиг хэрэг, тушаал шийдвэр, цаг бүртгэл, ажлын төлөвлөгөө зэргийг албан хэрэг хөтлөлтийн Able, office 365 программыг ашиглан явуулж байна. Мөн санал асуулга, асуумж, кайзен саналуудыг өөрсдийн хөгжүүлсэн цахим сүлжээ ашиглан явуулж байна.
- Хуулийн 15.2.5-д заасны дагуу хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж насжилтын судалгаа хийн, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэн 64%-г барагдуулсан.
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулснаар төлөвлөгөөтэй харьцуулахад түлшний зардал 537.3 сая төгрөг, ус 410.2 сая төгрөг, шатахуун 136.1 сая төгрөг, урсгал зардал 50.4 сая төгрөг, гаднаас худалдан авах цахилгаан 23.9 сая төгрөг, Ерөнхий болон удирдлагын зардал 109.3 сая төгрөг, зар суртчилгааны зардал 9.2 төгрөг, борлуулалтын шимтгэл 100.5 сая төгрөг, цахилгаан түгээлтийн алдагдал болон ашиглалтын цахилгаан 84.5 сая төгрөг, АНЗ 470.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд 2022 онд манай хамт олон нийт 2,597.2 сая төгрөгийн хэмнэлт гарган ажиллалаа.

## **“ЭРДЭНЭТИЙН ДЦС” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ОНЦЛОХ 9 ҮЙЛ ЯВДАЛ**

### **1. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2022 ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛААР ШАЛГАРСАН**



“Эрдэнэтийн ДЦС ТӨХК”-ийн суурилагдсан хүчин чадлыг СС-35 МВт Турбогенератороор өргөтгөх бүтээн байгуулалтын төслийн ажлыг амжилттай хэрэгжүүлж, ашиглалтад оруулан, хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай эрчим



хүчээр хангах үйлсэд идэвх санаачилга гаргасныг сайшаан үнэлж, “Эрчим хүчний салбарын 2022 оны шилдэг бүтээн байгуулалтын ажил”-аар шалгаруулсан.

## 2. ТҮҮХЭН ДЭЭД АМЖИЛТЫН ЖИЛ

Станц ашиглалтад орсноос хойш 36 жилийн хугацаанд тус онд цахилгаан эрчим хүчний боловсруулалтыг 434.5 сая.кВтц-д хүргэж, оргил ачаалалд 73 МВт авч, ДХЦЭХ-ийг хамгийн бага буюу 13.5% болгон буулгаж, түүхэн дээд амжилт гаргасан жил байлаа.



Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь хэмжээг ашиглалтад орсноос хойш хамгийн бага хувьд хүргэж ажиллав.



## 3. ЗУУХ №1.3-ИЙН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЖ, ӨВЛИЙН ИХ АЧААЛЛЫГ АМЖИЛТТАЙ ДАВСАН

БЗК-75-39фб маркийн Зуух №1-ийн их засварын ажлыг дотоод нөөц бололцоог ашиглан зуухан цехийн засварын хэсгийн ажилтнуудаар гүйцэтгүүлж, Зуух №3-ын



их засварын ажлыг Эрчим хүчний засвар, угсралтын “СММ” ХХК-иар гүйцэтгүүлснээр өвлийн их ачааллын хугацаанд үндсэн тоноглолын бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангаж, горим ажиллагааны хүндрэлгүй, зуухны графикт бус зогсолтын тоог багасгаж, өвлийн их ачааллыг амжилттай давсан.



#### **4. ПТ-12-35/10М МАРКИЙН ТУРБИН №1-ЫН ИХ ЗАСВАРЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН**

Турбогенератор №1-ийн их засварын ажлаар өндөр даралтын 21ш цахилгаан болон гар хаалт, урсгал хэсгийн нягтруулгууд, диафрагмын сегмент, пулской пружин, бүлэг клапангийн шток 2ш, тулах холхивчны колодка, пластин, стопорны клапангийн гол 2ш, цахилгаан ачааллын синхронизаторын холхивч, дулааны отбор, үйлдвэрийн отборын сильфон зэргийг шинээр сольж, тохиргоо хийсэн. 1,2,3,4-р холхивчинд үзлэг засвар хийж, маслотбойник, маслын ерөнхий насосны нягтруулагч кольцог шинээр сольж, удирдлагын шинэчлэлийг хийж, компьютерын





## 7. ЦООЖ ПАЙЗНЫ СИСТЕМ

Цахилгаан болон дулаан-механикийн тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх, технологийн болон засвар, угсралт, туршилт, тохируулгын ажлыг наряд, шийдвэрийн дагуу гүйцэтгэх үед тоног төхөөрөмжийг эрчим хүчний бүх төрлийн аюултай эх үүсвэр, хорт бодисын эх үүсвэрээс тусгаарлаж, ажилтныг осол, эрсдэлгүй ажиллуулахын тулд 2022 онд цоож, пайзны системийн журмыг боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн ажиллаж байна.




## 8. ОРХОН АЙМГИЙН “ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА”-ААР ШАЛГАРАВ

Орхон аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас уламжлал болгон зохион байгуулдаг “Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэгч” уралдаанд шилдэг байгууллагаар 3 дахь удаагаа шалгарч, дурсгалын цом, мөнгөн шагналаар шагнуулав.



## 9. “ТЭРБУМ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 1000 ширхэг мод үнсэн сангийн дэргэд Эрдэнэт голын дагуу хашаалж тарьсан. Компанийн хашаан дотор ашиглагддаггүй байсан 500 м2 талбайд модны үрсэлгээний газар байгуулж 4535 ширхэг бургасны үрсэлгээ хийж, 1.2-1.8 метр өндөр 90-95 хувьтай ургасан. Ирэх жилийн мод тарилтаар үрсэлгээ гаднаас худалдаж авахгүй нөхцөл бүрдүүлсэн



## IX. 2023 ОНД ТАВЬЖ БУЙ ЗОРИЛТ

- 2023 оны Зорилтот түвшингийн үзүүлэлтүүдийг бүрэн ханган биелүүлэх, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах
- СС-35 МВт-ын турбогенераторын өргөтгөлийн хүрээнд ашиглалтад орсон тоног, төхөөрөмжүүдийг бүртгэлд тусгах.
- 2023 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажил, өөрийн хөрөнгө оруулалт, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
- Хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, өмч эзэмшлийн гэрээг биелүүлж, амжилттай дүгнүүлэх.
- ХАБЭА-н ажлын хүрээнд хүрсэн түвшинг бататган, аварь, осолгүй ажиллах.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1500 ширхэг мод тарьж, 100% ургуулах ажлыг зохион байгуулах.
- Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллах.
- ISO 9001:20158, ISO 45001 хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх.

**“ЭРДЭНЭТИЙН ДЦС” ТӨХК**